



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/99

Чингис хот

Цалингийн шатлал ахиулж,  
ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг шинэчлэн батлах тухай 218 дугаар, 2018 оны “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам” батлах тухай 382 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “хангалттай сайн” үнэлүүлсэн тул “Хэнтий Шинэс” сум дундын ойн ангийн дарга Гонгорнамсрайн Мөнх-Оргилын албан тушаалын цалингийн шатлалыг нэмэгдүүлж ТҮ-9-3 болгож ахиулсугай.

2. Төрийн албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцон олгосугай.

3. Г.Мөнх-Оргилын цалингийн шатлал, ур чадварын нэмэгдлийг дээрх хэмжээгээр тооцон жилийн төсөвт багтаан тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ногдох албан тушаалын цалингаас тооцож 2021 оны 02 сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр олгохыг “Хэнтий Шинэс” сум дундын ойн ангийн нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тазьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010290